



Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2022 оны 3 дугаар улирлын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн товч танилцуулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг 201 байгууллага нь 2022 оны 2 дугаар улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 22243 мэдээлэл байршуулах ёстойгоос 92,6% буюу 20608 мэдээллийг хуулийн хугацаанд, 6,9% буюу 1545 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол, 0,4% буюу 90 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92.6 хувьтай гарлаа.




Мэдээлэл байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Мэдээлэл байршуулалтыг байгууллагын төрлөөр нь ангилан харуулбал:

Төсвийн 1 байгууллага 3-р улирлын байдлаар 111 мэдээлэл байршуулах ёстой ба 172 байгууллага нийтдээ 21468 мэдээлэл байршуулах ёстойгоос 19945 мэдээллийг хуулийн хугацаанд, 1414 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан боловч 24 байгууллага 59 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92.9 хувьтай гарлаа.




Диаграмм 3. Шилэн дансанд мэдээлэл

байршуулалт


Диаграмм 3. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт

Төрийн сан 3-р улирлын байдлаар 1 байгууллага 116 мэдээлэл, 20 төрийн сан нийтдээ 2338 мэдээлэл байршуулахаас 2165 мэдээллийг хуулийн хугацаанд, 163 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 10 мэдээллийг огт байршуулаагүй ба мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 92,6 хувьтай байна.



Диаграмм 4 Төрийн сангуудын мэдээлэл байршуулалт

Орон нутгийн өмчит 9 байгууллага нь нийт 815 мэдээлэл байршуулахаас 663 мэдээллийг хуулийн хугацаанд, 131 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 21 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 81,3 хувьтай гарлаа.



Диаграмм 5. Орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээлэл байршуулал

Зургаа. Шалгалтын дүгнэлт

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагддаг 201 байгууллагын 2022 оны шилэн дансны мэдээ тайланг хуулийн хугацаанд байршуулсан байдал, шилэн дансны системд улирлын мэдээг илгээсэн байдал, шилэн дансны шинэ цахим системд бүртгүүлсэн байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Энэ удаагийн шалгалтаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 92,6%, хуулийн хугацаанд мэдээ илгээлт 88,9%-тай, шилэн дансны шинэ цахим системд бүртгүүлэлт хангалтгүй буюу 35.32 хувьтай байгаа зөрчлүүд илэрлээ.

Шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд гарч байгаа зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал, мөн мэдээлэл байршуулалтад тавих удирдлагын болон дотоод хяналт байхгүй зэргээс шалтгаалж байгаа тул цаашид төсвийн шууд захирагч нар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үүнд дотоод хяналтын нэгжийг татан оролцуулах мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн ажлын хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаг болох, мэдээлэл байршуулж байгаа албан хаагчид шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв байршуулах, мэдээлэл хоорондын уялдааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Долоо. Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв хуулийн хугацаанд байршуулж байгаа эсэхэд улиралд нэгээс доошгүй удаа хяналт тавих.
2. Байгууллагуудыг Шилэн дансны шинэ нэгдсэн цахим системд бүртгүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах.